

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх хангамж нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/019/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn
	Гэрээгээр гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн захирал: Д.Товуудорж Утас: 9904-9511 Цахим хаяг: medeelelaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/274
танай _____-ны № _____-т

НАЛАЙХ ХАНГАМЖ, НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
В.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайх хангамж нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны А-234/А-359 дугаар тушаалаар баталсан "Сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалт"-ын дагуу Налайх дүүргийн 6 сургууль, 13 цэцэрлэг, Эрдмийн оргил цогцолбор сургуулийн дотуур байр, Эрүүл мэндийн төв, Багахангай дүүргийн сургууль цэцэрлэг, эрүүл мэндийн төвд эрүүл аюулгүй бараа бүтээгдэхүүнээр хангаж ажилласан байна.

Нийслэлийн Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр тогтоолоор Налайх Хангамж, нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-аас төсвийн байгууллагуудад нийлүүлэх хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийг үйл ажиллагааны зардлын өртгийг шингээсэн нэмэгдлийг бараа бүтээгдэхүүн тус бүрт 10 хувиас хэтрүүлэхгүй байхаар тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийт 2,505,219.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,274,734.4 мянган төгрөгийн зардал гарган, 151,576.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,012,129.82	770,890.28
1.1.2	Дансны авлага	149,335,934.00	
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага		24,339,225.56
1.1.4	Бусад авлага	45,000.00	
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	6,573,852.86	18,870,327.10
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо		11,985,794.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	156,966,916.68	55,966,236.94
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	18,166,191.68	41,877,008.60
1.2.2	Биет бус хөрөнгө	13,200.00	6,600.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,179,391.68	41,883,608.60
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	175,146,308.36	97,849,845.54
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	74,748,074.00	41,250,240.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	71,691,588.80	17,586,067.58
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	146,439,662.80	58,836,307.58
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	146,439,662.80	58,836,307.58
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- Хувьцаат		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	28,770,244.80	28,770,244.80
2.3.9	Өмнөх үеийн үр дүн	(15,182,998.06)	(141,333,126.09)
2.3.10	Тайлант үеийн үр дүн	15,119,398.82	151,576,419.25
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	28,706,645.56	39,013,537.96
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	175,146,308.36	97,849,845.54

Налайх хангамж, нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,057,354,676.18	2,370,512,206.35
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,850,993,505.70	2,019,810,095.10
3	Нийт ашиг (алдагдал)	206,361,170.48	350,702,111.24
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		442,963.82
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	48,000,000.00	134,545,454.55
9	Борлуулалт, маркетингийн зардал	88,849,209.13	73,308,941.02
10	Ерөнхий ба удирдлагын зардал	147,276,483.05	211,532,424.40
11	Санхүүгийн зардал	100,834.01	114,814.52
12	Бусад зардал	3,015,245.47	27,649,495.45
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(1,435,000.00)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	15,119,398.82	171,649,854.22
19	Орлогын татварын зардал		20,073,434.97
20	Татварын дараах ашиг (алдагдал)	15,119,398.82	151,576,419.25
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	15,119,398.82	151,576,419.25
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
	Орлогын нийт дүн	15,119,398.82	151,576,419.25

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл		28,770,244.80	(63,599.24)	28,706,645.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(141,269,526.85)	(141,269,526.85)
Залруулсан үлдэгдэл		28,770,244.80	(141,269,526.85)	(112,562,881.29)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			151,576,419.25	151,576,419.25
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг				
Дахин үнэлгээний нэмэгдэл				
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл		28,770,244.80	10,243,293.16	39,013,537.96

Налайх хангамж, нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,170,122,062.30	2,708,230,124.75
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,121,868,998.00	2,559,615,551.00
	Татаас, санхүүжилтын орлого	40,000,000.00	148,000,000.00
	Бусад мөнгөн орлого	8,253,064.30	614,573.75
1.2	Мөнгөн зарлага (-)	2,191,339,414.89	2,642,143,314.82
	Ажиллагчдад төлсөн	97,865,029.00	143,033,807.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	28,083,465.68	40,782,951.36
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,992,794,724.27	2,281,011,580.00
	Ашиглалтын зардалд төлсөн	11,680,586.11	20,808,132.03
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,362,685.00	14,499,690.00
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	32,514,870.82	84,659,575.75
	Даатгалын төлбөрт төлсөн	496,010.00	496,010.00
	Бусад мөнгөн зарлага	8,542,044.01	56,851,568.68
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(21,217,352.59)	66,086,809.93
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		108,390.07
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүний орлого		108,390.07
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		66,195,200.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		66,195,200.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(66,086,809.93)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(21,217,352.59)	(241,239.54)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,229,482.41	1,012,129.82
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,012,129.82	770,890.28

Налайх хангамж, нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
1	Борлуулалтын орлого	2,397,100.2	2,370,232.2	(26,868.0)	98.9
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг (ББӨ)	2,100,132.7	2,019,810.0	(80,322.7)	96.2
3	Үйл ажиллагааны ашиг	296,967.5	350,702.1	53,734.6	118.1
	Хүүний орлого		443.0	443.0	
	Бусад орлого		134,545.5	134,545.5	
4	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	206,983.3	153,985.3	(52,998.0)	74.4
4.1	Үндсэн цалин	119,816.4	107,933.3	(11,883.1)	90.1
4.2	Унаа хоолны зардал	14,112.0	10,913.0	(3,199.0)	77.3
4.3	Шагнал, урамшуулал, үр дүн, үр чадвар	60,382.8	35,139.0	(25,243.8)	58.2
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,872.9	40,782.9	14,910.0	157.6
6	Үйл ажиллагааны зардал	61,761.3	79,276.7	17,515.4	128.4
6.1	Ажлын байр ашиглалттай холбоотой зардал	11,127.6	18,949.2	7,821.6	170.3
6.1.1	Гэрэл цахилгаан	1,904.8	1,225.5	(679.3)	64.3
6.1.2	Түлш, халаалт	4,672.8	3,959.3	(713.5)	84.7
6.1.3	Байрны түрээс / граж түрээс	4,550.0	13,764.4	9,214.4	302.5
6.2	Хангамжийн бараа материалын зардал	28,816.3	22,730.2	(6,086.1)	78.9
6.2.1	Бичиг хэрэг	2,222.1	1,879.7	(342.4)	84.6
6.2.2	Тээвэр шатахуун	22,365.2	11,475.0	(10,890.2)	51.3
6.2.3	Шуудан харилцаа холбоо	830.0	830.0	0.0	100.0
6.2.4	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	2,319.0	6,025.8	3,706.8	259.8
6.2.5	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал	1,080.0	1,080.0	0.0	100.0
6.3	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр	497.4	18,000.0	17,502.6	3619
6.4	Бараа үйлчилгээний бусад зардал	7,660.0	6,348.2	(1,311.8)	82.9
6.4.1	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	700.0	680.0	(20.0)	97.1
6.4.2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, нэг удаагийн урамшуулал	1,800.0	5,668.2	3,868.2	314.9
6.4.3	Бусад зардал	5,160.0	-	(5,160.0)	
7	Тоног төхөөрөмж	6,000.0	66,195.2	60,195.2	1103.3
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ	286,957.5	254,921.4	(32,036.1)	88.8

Налайх хангамж, нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 217,634.6 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Урьдчилж өгсөн 11,985.8 мянган төгрөгийн бараа материалыг дансны авлагаар бүртгэж санхүүгийн тайланд буруу ангилж тайлагнасан	1	11,985.8			1	11,985.8	1	11,985.8				
2	Үндсэн хөрөнгийн 11,929.9 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 9 компьютер, бусад хэрэгслийг тоног төхөөрөмжөөр бүртгэн авч үндсэн хөрөнгийн тодруулгын ангилал буруу тайлагнасан	1	11,929.9			1	11,929.9	1	11,929.9				
3	УБ Эрүүл мэндийн төвөөс авах авлагын үлдэгдэлийг тайлант оны орлогоор тайлагнаж тус дүнгээр баримтаар нотлогдогүй зардалаар тайлагнасан нь	1	145,089.1			1	145,089.1	1	145,089.1				
4	2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогын дүн, ерөнхий журналын дүн 48,629.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан	1	48,629.7			1	48,629.7	1	48,629.7				
	Дүн	4	217,634.6			4	217,634.6	4	217,634.6				

Налайх хангамж, нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитаар нийт 2,200.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 880.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,320.0 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орлогын дэлгэрэнгүй тайланд тайлагнасан цалингийн зардал, НДШ тайланд тайлагнасан цалингийн зардал 1,320.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	1,320.0					1	1,320.0				
2	Үйл ажиллагааны бус торгуулийн зардалд 880.0 мянган төгрөгийн зардал гарсан	1	880.0	1	880.0								
	Дүн	2	2,200.0	1	880.0			1	1,320.0				

Налайх хангамж, нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 22,730.2 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын нэр "Налайх хангамж, нийтлэг үйлчилгээний төв", байгууллагын дүрэм дээр "Налайх Хангамжийн төв" оноосон нэртэй байна гэж заасан нь хууль эрх зүйн актад байгууллагын нэр зөрүүтэй байна	1						1	
Байгууллагын хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна	1	22,730.2					1	22,730.2
Шилэн дансанд 4-н мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна	1						1	
Нийт дүн	3	22,730.2					3	22,730.2